

- 5.12.10. Холбооны бэлэгдэл, шагнал, медалийн загварыг батлах;
- 5.12.11. Мэргэжлийн зөвлөлийн саналыг үндэслэн шигшээ багийн ахлах дасгалжуулагч, дасгалжуулагч, тамирчдыг батлах;
- 5.12.12. Өөрийн бүрэн эрхийн хүрээнд тэмцээн зохион байгуулах талаар шийдвэр гаргаж, хэрэгжилтэд хяналт тавих;
- 5.12.13. Жил бүрийн эцэст Ерөнхийлөгчийн бодлого чиглэлийг харгалзан, Холбооны ирэх жилийн төсөв, дотоодод тэмцээн уралдаан зохион байгуулах, гадаадын тэмцээн уралдаанд оролцох нэгдсэн хөтөлбөр, төлөвлөгөөг батлах;
- 5.12.14. Олон улсын тэмцээн, арга хэмжээнд оролцох тамирчин, дасгалжуулагч, мэргэжилтэн, төлөөлөгчдийн бүрэлдэхүүнийг тогтоох;
- 5.12.15. Шаардлагатай гэж үзсэн бусад асуудал.
- 5.13. Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд Удирдах зөвлөлийн гишүүдийн олонхи нь хуралд оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно. Удирдах зөвлөлийн хуралд оролцож байгаа гишүүдийн олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно.
- 5.14. Удирдах зөвлөлийн хуралд аливаа асуудлыг шийдвэрлэхэд гишүүн бүр саналын нэг эрхтэй байна. Удирдах зөвлөлийн гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд даргын саналаар уг асуудлыг шийдвэрлэнэ.
- 5.15. Удирдах зөвлөлийн дарга нь Холбооны Ерөнхийлөгч байна. Удирдах зөвлөлийн дарга нь удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулж, хурлыг зарлан хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, хяналт тавина.
- 5.16. Удирдах зөвлөл нь бүрэн эрхийн хугацаанд бүрэлдэхүүндээ тодорхой шалтгаанаар /нас барсан, гадаадад явсан, өөрөө татгалзсан/ 30 хүртэлх хувийн өөрчлөлт оруулж болох бөгөөд үүний Ерөнхийлөгч шийдвэрлэнэ.
- 5.17. Удирдах зөвлөлийн хуралдаанаар шийдвэрлэх асуудлаар ашиг сонирхлын зөрчилтэй гишүүн байвал энэ тухайгаа мэдэгдэж, санал хураалтад оролцохгүй байх үүрэгтэй.
- 5.18. Удирдах зөвлөл улиралд нэгээс доошгүй удаа хуралдана.
- 5.19. Удирдах зөвлөл жилийн эцсийн хурлаа Мэргэжлийн зөвлөл, Ёс зүйн зөвлөл, Хяналтын зөвлөлийг оролцуулан өргөтгөсөн хэлбэрээр явуулна.
- 5.20. Удирдах зөвлөлийн хурлын шийдвэр нь тогтоол хэлбэртэй байна. Тогтоолд Удирдах зөвлөлийн дарга гарын үсэг зурна.
- 5.21. Удирдах зөвлөлийн гишүүн жилд **3,000,000 /гурван сая/-аас** доошгүй төгрөгийг холбооны үйл ажиллагааны зардалд зориулан дэмжлэг хэлбэрээр оруулна. Энэхүү заалт нь тус дүрэмийн 5.9.1.-5.9.4.-т тусгасан төрийн байгууллагуудын төлөөлөл болох Удирдах зөвлөлийн гишүүнд хамаарахгүй ба тухайн гишүүдэд ногдох санхүүгийн дэмжлэгийг Холбооны ажлын албаны ивээн тэтгэлт, санхүү хариуцсан нэгж бүрдүүлж болно.

Ерөнхийлөгч

ХУУЛБАР
 Гарын үсэг
 20...

- 5.22. Холбооны Ерөнхийлөгч нь нийгэмд нэр хүндтэй, улс төр, бизнесийн салбарт нөлөө бүхий, уулынспортыг хөгжүүлэх чин эрмэлзэлтэй, удирдан зохион байгуулах дадлага туршлагатай, уулын спортын аль нэг төрлөөр тодорхой хэмжээнд хичээллэж байсан, байгаа Монгол Улсын иргэн байна.